

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ЗУРГААДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны хоёрдугаар сарын 16 -ны 10 цаг 45 минутад эхэлж, 11 цаг 54 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 309 тоот өрөө)-д болж, 1 цаг 09 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах тухай	<p>Монгол Улсын Хилийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц орон тоог батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/24 дүгээр тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"><li>- Газрын дарга</li></ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Газрын Дэд дарга</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Тамгын газрын дарга</li> <li>- Виз, зөвшөөрлийн газрын дарга</li> <li>- Хяналт шалгалтын газрын дарга</li> <li>- Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга</li> <li>- Санхүүгийн хэлтсийн дарга</li> <li>- Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн дарга</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тамгын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн.</li> </ul> <p>2. Төрийн албаны зөвлөлийн тус газрын дэргэдэх Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа, сургалт хөгжил, төрийн албанд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албаны нөөцийн санг бүрдүүлэх чиг үүргийн хэрэгжүүлэхэд мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад тус тус зөвлөх</p> <p>3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, санаачилагатай ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар</p>
--	--	---

		<p>зөвлөл /Д.Мөрөн/-д үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 193 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр дэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн батлах. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засаг даргын Тамгын газрын дарга</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга</li> <li>- Ерөнхий аудитор</li> <li>- Шүүхийн Тамгын газрын дарга</li> <li>- Цагдаагийн газрын дарга</li> <li>- Мэргэжлийн хяналтын газрын дарга</li> </ul>

		<ul style="list-style-type: none"><li>- Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга</li><li>- Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга</li><li>- Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга</li><li>- Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга</li></ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"><li>- Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга</li></ul> <p>2. Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, төрийн албанд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албаны нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг гишүүн С.Цэдэндамбад тус тус зөвлөсүгэй.</p> <p>3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх</p>
--	--	---

		<p>ажлыг зохион байгуулж, санаачилагатай ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Д.Содном/-д үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 6 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 6 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилох тухай” мөн Зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	"Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Нэг. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнах</p> <p>2. Хоёр. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр</p>

		<p>шагнагдсан хүн бүрт уг шагналыг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг шагнуулахаар нэр дэвшүүлсэн тухайн байгууллага Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу шийдвэрлэх</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**